



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга” төслийн хэрэгжилтэд хийсэн эрсдэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилт үр дүнг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн сайд /Д.Сарангэрэл/-д зөвлөсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /Б.Мөнх-Очир/-т даалгасугай.

5. Аудитын тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Хаш-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт.....	3
Дүрслэлийн жагсаалт.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Ерөнхий мэдээлэл.....	6
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАГДААГҮЙ БАЙХАД ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХИЙСЭН НЬ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭХ, ХЭРЭГЖИЛТ УДААШРАХАД НӨЛӨӨЛСӨН БАЙНА.....	8
<i>Нэгдсэн эмнэлгийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавраар барилгажих талбайн схем зургийн эргэлтийн цэгийн солбицлыг барилгын норм ба дүрмийн дагуу тогтоогоогүйгээс барилгын суурийг шилжүүлж, төсөвт тусгаагдаагүй 179.8 сая төгрөгийн зардал гаргажээ</i>	<i>8</i>
<i>Нэгдсэн эмнэлгийн хуучин туслах барилга, байгууламжийг буулгахдаа буулгалтын ажлын акт үйлдээгүй байна.....</i>	<i>8</i>
<i>Барилгын эх загвар зураг (эскиз) боловсруулах гүйцэтгэгчийг АХБ-ны худалдан авах ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулжээ</i>	<i>9</i>
<i>Инженер-геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд дүрэм, журмын дагуу олгогдсон байна</i>	<i>11</i>
<i>Зураг төсөл зохиогч барилгын бүтээцийн угсралтын ажлын зургийг орхигдуулснаас барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэхэд бэрхшээл үүссэн байна.....</i>	<i>12</i>
<i>Барилгын зураг төслийн цахилгаан хангамжийн хэсгийг барилгын норм ба дүрмийн дагуу зураагүйгээс зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн байна</i>	<i>14</i>
<i>Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын төсвийг зургаас зөрүүтэй тооцсоноос төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн байна.....</i>	<i>15</i>
<i>Барилгын хөгжлийн төвийн хянасан төсвөөс тендерт шалгарсан төсөв 9.8 тэрбум төгрөгөөр илүү байна.....</i>	<i>15</i>
<i>Нэгдсэн эмнэлэг барих төслийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааны үе шатанд 4 жил 3 сарын хугацааг зарцуулжээ</i>	<i>18</i>
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ҮҮСЭЖ БҮЙ АСУУДЛУУДЫГ ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭЖ, ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААНД ДУУСГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	19
<i>Ажил гүйцэтгэх гэрээг FIDIC загвараар байгуулснаас ажлын тоо хэмжээ, өртөгт өөрчлөлт орох эрсдэлтэй байна</i>	<i>19</i>
<i>Ажлын үр дүн ерөнхий гүйцэтгэгч бүрэн хариуцахаар байна</i>	<i>19</i>
<i>Эрүүл мэндийн яам төслийн нэмэлт санхүүжилтийн хэлэлцээр байгуулаагүй байхад нэмэлт ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, 3.9 сая ам.долларын санхүүжилтийг олгуулсан байна</i>	<i>20</i>
<i>Гадна зам талбайн тохижилт, авто машины зогсоол байгуулах ажлын зураг төсөл боловсруулагдах шатанд байна</i>	<i>21</i>
<i>Гүйцэтгэгчийн ирээдүйд хийх ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, 826.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгуулсан байна</i>	<i>21</i>
<i>Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл болон олгосон санхүүжилтийг тулган баталгаажуулахад 1,693.5 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.....</i>	<i>22</i>
<i>Засгийн газрын 2014 оны 93 дугаар тогтоолыг зөрчин захиалагчийн хяналт хийх байгууллагыг сонгосон байна</i>	<i>22</i>
<i>Барилгын норм ба дүрмийн дагуу зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж байна.....</i>	<i>23</i>
<i>Барилгын төслийн хэрэгжилтийн явцад холбогдох байгууллагаас хяналт хийж, зөвлөмж өгсөн байна.....</i>	<i>24</i>
<i>Эмнэлгийн гадна бохир усны шугамыг холбосон төвийн шугам ачааллаа даахгүй байх эрсдэл үүссэн байна.....</i>	<i>24</i>
Дүгнэлт	25
Зөвлөмж	26
Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн санал.....	27
Хавсралтууд.....	28



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БНБД	Барилгын норм ба дүрэм
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨК	Төрийн өмчит компани
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТББ	Тендерийн бичиг баримт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	Нэгдсэн эмнэлгийн барилга угсралт болон барилга угсралтын үед суурилагдах тоног төхөөрөмжийн зардлын дүн, сая ам.доллар	6
2	Тендерт оролцох компанийн хүсэлтийг үнэлсэн судалгаа, оноогоор	9
3	Тендерт оролцогчдыг техникийн болон санхүүгийн саналыг үнэлсэн судалгаа, оноогоор	10
4	Зөвлөх үйлчилгээнд олгосон санхүүжилт, мөнгөн дүнгээр	11
5	Техникийн нөхцөл олгосон судалгаа	12
6	Тендерт оролцох хүсэлтийг үнэлсэн судалгаа, оноогоор	12
7	Тендерт оролцогчдыг үнэлсэн судалгаа, оноогоор	13
8	Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид олгосон санхүүжилтийн гүйцэтгэл, ам.доллороор	14
9	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүд	16
10	Тендерт оролцсон компанийн шалгараагүй шалтгаан	17
11	Төсөл хэрэгжүүлэх үе шатанд зарцуулах хугацаа, жил, сараар	18
12	Ерөнхий болон туслан гүйцэтгэгчийн ажил үүргийн хуваарь	19
13	Гүйцэтгэгч компанид олгосон санхүүжилтийн мэдээлэл	20
14	Санхүүжилт авсан ирээдүйд хийгдэх ажлын жагсаалт, мөнгөн дүнгээр	22
15	Илүү тооцсон материалын тоо хэмжээ, үнийн задаргаа	22
16	Захиалагчийн хяналтын зардлын задаргаа	23
17	Зохиогчийн хяналтын зардлын санхүүжилт олгосон байдал	23

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Дүрслэлийн нэр	Хуудасны дугаар
1	Барилгын хөгжлийн төвийн хянасан төсөв болон тендерт ирүүлсэн саналын харьцуулсан судалгаа, мянган ам.доллар	17

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Аудитаар Эрүүл мэндийн яаманд АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4+” төслийн хүрээнд баригдаж байгаа Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 200 ортой Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын явц, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Төслийг хэрэгжүүлэх үе шатны ажлыг зохистой төлөвлөж, зохион байгуулсан эсэх;
- Төслийн үйл ажиллагаа үр дүнтэй, хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4+” төслийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, зээлийн зарцуулалт, тайлагналтай холбоотой баримт материалд тулгуурлан Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Төслийн удирдах хороо, Төсөл хэрэгжүүлэгч нэгж, барилга угсралтын ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагааг хамруулан шалгав.

Аудитын арга зүй:

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100) болон Гүйцэтгэлийн аудитын журмын дагуу Эрүүл мэндийн яам, Төслийн нэгж, гүйцэтгэгч байгууллагуудын худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, бусад баримт материалд дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг ашиглан нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль /2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүйд тооцсон/,
- Өрийн удирдлагын тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль,
- Буцалтгүй тусламжийн гэрээ /2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 0236 MON (SF) дугаар/
- Зээлийн гэрээ /2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 2932 MON (SF) дугаар/
- Монгол Улсын 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай” хууль,
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга

хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”,

- Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журам,
- Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”,
- Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”,
- Холбогдох бусад хууль, эрхийн актууд.

Аудитын хүндрэл бэрхшээл:

“Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн жишиг Нэгдсэн эмнэлгийн барилга” төслийн хэрэгжилт, үр дүнд эрсдэлийн аудит хийх явцад тус төслийн гэрээ, хэлэлцээр, худалдан авах ажиллагаа болон санхүүгийн баримт материал, бусад холбогдох баримтууд англи хэл дээр үйлдэгдсэн тул тухайн баримт материалын агуулгыг бүрэн ойлгоход хүндрэлтэй байсан болно.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газар болон АХБ-ны хооронд 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан 14.0 сая ам.долларын дүнтэй, 0236-MON(SF) дугаартай, “Буцалтгүй тусламжийн гэрээ”-ний хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн жишиг Нэгдсэн эмнэлгийн барилгын төсөлд 4.0 сая ам.долларын санхүүжилтийг АХБ-ны буцалтгүй тусламжаар олгохоор батлагдсан байна.

Мөн “Буцалтгүй тусламжийн гэрээ”-нд батлагдсан тус Нэгдсэн эмнэлгийн барилгын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нэмэлт санхүүжилт болох 16.2 сая ам.долларын зээлжих тусгай эрхтэй тэнцэх 25.0 сая ам.долларын дүнтэй, 2932 MON (SF) дугаартай зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдөр нэмэлтээр байгуулж, 2013 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Монгол Улсын хуулиар “Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон баталсан байна.

Тус зээлийн гэрээний дүнгээс 18.0 сая ам.доллар нь Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажилд зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

АХБ-наас 2012 оны 10 дугаар сард гаргасан 41243 дугаартай “Төсөл хэрэгжүүлэх гарын авлага”-д Монгол Улсын Засгийн газар буцалтгүй тусламжийн хүрээнд 3.7 сая ам.доллар, зээлийн хүрээнд 2.0 сая ам.долларын санхүүжилтийг тус тус гаргахаар тусгасан байна. Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлэх нийт 5.7 сая ам.доллароос барилга угсралтын ажил болон барилга угсралтын үед суурилагдах тоног төхөөрөмжид 2.8 сая ам.доллар зарцуулагдахаар байна.

Хүснэгт 1. Нэгдсэн эмнэлгийн барилга угсралт болон барилга угсралтын үед суурилагдах тоног төхөөрөмжийн зардлын дүн, сая ам.доллар

Д/д	Эх үүсвэрийн нэр	Эрх зүйн үндэслэл	Нийт дүн	Үүнээс:	
				Барилга угсралтын ажлын дүн	Барилга угсралтын үед суурилуулах тоног төхөөрөмжийн дүн
1	АХБ-ны буцалтгүй тусламж	Буцалтгүй тусламжийн гэрээ	14.0	-	4.0
2	АХБ-ны зээл	Зээлийн гэрээ	25.0	18.0	-
3	Монголын талын хөрөнгө	Төсөл хэрэгжүүлэх гарын авлага	5.7	2.0	0.8
4	ДЭМБ	Төсөл хэрэгжүүлэх гарын авлага	0.45	-	-
Нийт			45.15	20.0	4.8

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Буцалтгүй тусламжийн гэрээ”, 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан “Зээлийн гэрээ”, АХБ-наас 2012 оны 10 дугаар сард гаргасан “Төсөл хэрэгжүүлэх гарын авлага”.

АХБ-ны буцалтгүй тусламж болон зээл нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хаагдаж, Монгол Улсын Засгийн газар зээлийг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2044 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл 6 сар тутамд 338,333.0 ам.долларын эргэн төлөлт хийхээр байна.

Нэгдсэн эмнэлгийн барилгын захиалагчаар Эрүүл мэндийн яам, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр Австри Улсын “Vamed engineering” ХХК, туслан гүйцэтгэгчээр “Магнус сентурион констракшн” ХХК, “Сэтунари” ХХК-ууд ажиллаж, захиалагчийн хяналтыг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ, зохиогчийн хяналтыг “Бьюлдингс технологжи” ХХК-ууд гүйцэтгэж байна.

Төслийн зорилго нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн эмнэлгийг олон төрлийн тусламж, үйлчилгээтэй жишиг нэгдсэн эмнэлэг болгон өөрчилж, үйл ажиллагааг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

Нэгдсэн эмнэлгийн барилга нийт 4 блок, үндсэн ба техникийн гэсэн 2 хэсгээс бүрдсэн байна.

Үндсэн барилга А, Б болон подиумын блок тэнхлэгээрээ 86.4м х 72.0м, техникийн блок тэнхлэгээрээ 36.0м х 18.0м хэмжээтэй, зоорьтой 2 давхар, нил хавтан суурьтай, А, Б блок нь тэнхлэгээрээ 21.6м х 72.0м хэмжээтэй, үүнээс барилгын гол хэсэг нь зоорьтой 28.8м х 21.6м хэмжээтэй нил хавтан суурьтай, 2 захын хэсэг нь зоорьгүй баганан суурьтай түргэн тусламжийн хэсэг 10.8м х 10.2м хэмжээтэй зоорьтой 1 давхар, барилгын нийт талбай 17,667.13м² үүнээс ашигтай талбай нь 11,545.11м² бүхий эмнэлгийн зориулалттай байна.

Барилгын үндсэн бүтээц нь цутгамал төмөр бетон баганан суурьтай, цутгамал төмөр бетон арагт хийцтэй байна.

Барилгын бүтээцийн төлөвлөлтийг цаг уурын гадна агаарын тооцооны температур -39⁰С, цасны ачаалал 50кг/м², гал тэсвэрлэлтийн зэрэг II, газар хөдлөлтийн 8 баллын нөхцөлд тохируулан төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГАГДААГҮЙ БАЙХАД ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХИЙСЭН НЬ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭХ, ХЭРЭГЖИЛТ УДААШРАХАД НӨЛӨӨЛСӨН БАЙНА

Нэгдсэн эмнэлгийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавраар барилгажих талбайн схем зургийн эргэлтийн цэгийн солбицлыг барилгын норм ба дүрмийн дагуу тогтоогоогүйгээс барилгын суурийг шилжүүлж, төсөвт тусгагдаагүй 179.8 сая төгрөгийн зардал гаргажээ

1.1. Нийслэлийн Засаг даргын 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 608 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн газрын албанаас 43/0014 дугаар нэгж талбар бүхий 0234760 дугаар төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээгээр Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 2010 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр эмнэлгийн зориулалттай 15399 м² газрыг Нэгдсэн эмнэлэгт 15 жилийн хугацаанд эзэмшүүлэхээр олгосон байна.

1.2. Газрын зөвшөөрлийг үндэслэн Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын дарга Н.Нацагдорж Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, дүүргийн 200 ортой Нэгдсэн эмнэлгийн архитектур төлөвлөлтийн 2015/159 дугаар даалгаврыг 2015 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан байна.

1.3. Тус даалгавраар Нэгдсэн эмнэлгийн газрын барилгажих талбайн схем зургийн эргэлтийн цэгийн солбицлыг орон сууцны барилга болон орчны барилга байгууламжийн хоорондын зай хэмжээг “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт” буюу барилгын норм ба дүрмийн 31-01-10-ийн 4.18, 4 дүгээр хавсралтад заасан хүснэгтээр тогтоох заалтыг зөрчин, барилгажих талбайн баруун урд байрлах орон сууцны 106 дугаар барилгатай тус эмнэлгийн барилгыг 2.8 метр, барилгын консолоос 1.5 метрийн зайд барихаар төлөвлөжээ.

1.4. Нэгдсэн эмнэлгийн барилгын зураг төслийг хийлгэх, барилга угсралтын ажлыг эхлүүлэх зэрэг бэлтгэл ажлын явцад барилгажих талбайн баруун урд талд байрлах орон сууцны 106 дугаар байрны оршин суугч, иргэн Б.Баяраас АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт “Эмнэлгийн барилга орон сууцны барилгатай ойрхон бөгөөд цонхноос 5 метрийн дотор зайд байгаа нь маш том асуудал болж байна” гэсэн агуулга бүхий гомдол гаргасан байна.

1.5. Иймд дээрх асуудлыг шийдвэрлүүлэхээр төсөл хэрэгжүүлэх нэгжээс Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт “Асуудал шийдвэрлүүлэх тухай” 200 дугаар албан бичгийг 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлснээр 2017 оны 8 дугаар сарын 11-ний өдөр архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицлыг шилжүүлж, дахин баталсан байна.

1.6. Схем зургийн эргэлтийн цэгийн солбицлыг барилгын норм ба дүрмийн дагуу тогтоогоогүйгээс Нэгдсэн эмнэлгийн барилгын суурь хойд зүгт 3 метр, зүүн тийш 7 метр шилжсэн бөгөөд гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөвт өөрчлөлт орж, 2018 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр баталсан ерөнхий төлөвлөгөө, эскиз зургийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлээр төсөвт тусгагдаагүй 82,876.32 ам.доллар буюу 179.8 сая төгрөгийн зардал гарах үр дагавар үүссэн байна.

Нэгдсэн эмнэлгийн хуучин туслах барилга, байгууламжийг буулгахдаа буулгалтын ажлын акт үйлдээгүй байна

1.7. Нэгдсэн эмнэлгийг шинээр барихтай холбогдуулан хуучин эмнэлгийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 718.3 сая төгрөгийн 5 барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, инженерийн шугам сүлжээг акталж, үндсэн хөрөнгөөс хасах тухай Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 113 дугаар тогтоол гарсан байна.

1.8. Дээрх тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор хуучин Нэгдсэн эмнэлгийн гал тогоо, гарааш, узель, архив, угаалга, моорог, улаан булан зэрэг туслах барилга, байгууламжийг буулгах, дулаан, цэвэр бохир усны шугамыг шилжүүлэн зайлуулах, узелийг шилжүүлж, шинээр барих зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэн худалдан авах ажиллагааны тендерийг зарлаж, сонгон шалгаруулалтаар “Хангилцаг” ХХК шалгарсан байна.

1.9. Эрүүл мэндийн яам, “Хангилцаг” ХХК-тай 2016 оны 7 дугаар сарын 06-ны өдөр 338.8 сая төгрөгийн БА 2015/001 дугаар “Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн туслах барилга, байгууламжийг буулгах, узель шинээр барих ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан байна. /Тус гэрээний хугацаа 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр дууссан/

1.10. Гүйцэтгэгч гэрээний дагуу барьсан узелийн барилга, байгууламжийг 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн БА 2015/001-01 дугаар актаар хүлээж авсан боловч барилга байгууламжийг буулгахдаа “Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааны дүрэм” БД 20-101-12-ийн дагуу “Барилга байгууламжийг буулгасан акт”-ыг үйлдээгүй байна.

Барилгын эх загвар зураг (эскиз) боловсруулах гүйцэтгэгчийг АХБ-ны худалдан авах ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулжээ

1.11. Нэгдсэн эмнэлгийн эх загвар зураг (эскиз) боловсруулах гүйцэтгэгчийг сонгох зөвлөх үйлчилгээний тендерийг Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан 2932-MON (SF) дугаар зээлийн гэрээний 4 дүгээр хавсралтын 1¹-д заасны дагуу АХБ-наас 2013 оны 3 дугаар сард баталсан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам”-ын хүрээнд зохион байгуулсан байна.

1.12. Эрүүл мэнд, спортын яам (хуучин нэрээр)-ны ТНБД-ын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 165 дугаар тушаалаар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн төлөвлөлт, барилгын зураг, төслийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн “Тушаал хүчингүй болгож, үнэлгээний хороо байгуулах тухай” 324 дүгээр тушаалаар үнэлгээний хороог 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дахин байгуулсан байна.

1.13. Үнэлгээний хороо тендерийн урилгыг дараах мэдээллийн хэрэгслээр нийтэлсэн бөгөөд тендерт оролцогчдын хүсэлтийг 2013 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 15:00 цагийн дотор хүлээн авахаар тусгажээ. Үүнд:

- “Өдрийн сонин”-ы 2013 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 165 (4492) дугаарын 11 дүгээр талд,
- “UB Post” сонины 2013 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн дугаарын 3 дугаар талд,
- АХБ-ны цахим хуудсанд 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдөр

1.14. Тендерийг нээхэд дараах 6 компани тендерт оролцох хүсэлт ирүүлснийг Үнэлгээний хорооноос 2013 оны 8 дугаар сарын 01-ний өдөр АХБ-ны “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу дэлгэрэнгүй жагсаалтыг гаргаж, 2008 онд АХБ-наас гаргасан зөвлөх үйлчилгээний гарын авлагын дагуу үнэлгээг хийж, 70 буюу дунджаас дээш оноо авсан “HB consultants”, “Kathy Roughan Health Planning”, “Meirovich consulting”, “Simed International B.V” компаниудыг шалгаруулан богино жагсаалтад оруулж, тендерийн баримт бичгийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 2. Тендерт оролцох компанийн хүсэлтийг үнэлсэн судалгаа, оноогоор

		Тендерт оролцох санал ирүүлсэн компанийн нэр, үнэлгээ				
Үнэлэх шалгуур	HB consultants Ltd – Бангладеш	Kathy Roughan Health planning Pty – Австрали	Mediconsult – Малайз	Resources Development Consultants Ltd – Шри-ланка	Meirovich consulting – Испани	Simed International B.V – Нидерланд
	оноо	оноо	оноо	оноо	оноо	оноо
1.Удирдлагын чадавх	20 оноо					
А	Бие даасан		15.0			16.0

¹ Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийт бараа таваар, ажил болон зөвлөх үйлчилгээ нь Худалдан авах ажиллагааны болон Зөвлөх үйлчилгээний журмын дагуу тус тус хийгдэнэ.



В	Түншлэл	15.5		12.0	15.0	17.5	
2. Техникийн чадавх		60 оноо					
А	Бие даасан		44.0				46.0
В	Түншлэл	41.0		35.0	37.0	49.0	
3. Бүс нутаг дахь ажлын туршлага		20 оноо					
А	Бие даасан		19.0				19.5
В	Түншлэл	14.8		10.0	7.2	14.8	
Нийт 100 оноо							
Нийт (Бие даасан)			78.0				81.5
Нийт (Түншлэл)		71.3		57.0	59.2	81.3	

Эх сурвалж: Төслийн нэгжийн худалдан авах ажиллагааны баримт материал

1.15. Үнэлгээний хорооны богино жагсаалтад орсон “Meirovich consulting” компани нь ашиг сонирхлын зөрчил үүссэн тул тус компанийн ирүүлсэн техникийн саналаас татгалзаж, санхүүгийн саналыг нээхгүй буцаах зөвлөмжийг АХБ-ны 2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр албан бичгээр ирүүлсэн байна.

1.16. Үнэлгээний хороо богино жагсаалтад үлдсэн дараах 3 компанийн техникийн болон санхүүгийн саналыг 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр үнэлэхэд “Simed International B.V” компани 912.5 буюу хамгийн өндөр оноог авч, нэгдүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 3. Тендерт оролцогчдыг техникийн болон санхүүгийн саналыг үнэлсэн судалгаа, оноогоор

Компанийн нэр	Техникийн саналын			Санхүүгийн саналын			Нийт үнэлгээ
	Үнэлгээ	Хувийн жин	Оноо	Үнэлгээ	Хувийн жин	Оноо	
	1	2	1*2=3	4	5	4*5=6	3+6=7
“HB Consultants” Ltd	782.9	0.8	626.3	909	0.2	181.8	808.1
“Kathy Roughan Health Planning” Ltd	778.3	0.8	622.6	985	0.2	197.1	819.7
“Simed International B.V”	890.6	0.8	712.5	1000	0.2	200.0	912.5

Эх сурвалж: Төслийн нэгжийн худалдан авах ажиллагааны баримт материал

1.17. Эрүүл мэнд, спортын яам (хуучин нэрээр), “Simed International B.V” компанитай 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах тухай хэлэлцээр хийж, 2014 оны 1 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 2015 оны 7 дугаар сарын 04-ний өдөр хүртэл 18 сарын хугацаанд үргэлжлэх 310,742.63 еврогийн гэрээг 2014 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр байгуулж, гарын үсэг зурсан байна.

1.18. Зөвлөх үйлчилгээний гэрээнд төлбөрийг “Simed International B.V” компанид 40 хувь, 50 хувь, 10 хувиар хувааж хийхээр тусгажээ.

1.19. Гэрээлэгч талууд Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, бүдүүвч зураг төслийн тайлан, тоног төхөөрөмжийн хуваарийн тайланг засварлах, зөвлөхийн нэмэлт замын зардалтай холбогдуулан 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдөр тус гэрээний дүнг 6,384.36 еврогоор нэмэгдүүлж, 317,126.99 евро болгосон байна.

1.20. Зөвлөх үйлчилгээний гэрээнд гүйцэтгэгч Нидерланд Улсын “Simed International B.V” компаниар дараах 3 багц ажлыг нийт 317,126.99 еврогоор гүйцэтгүүлэхээр тусгажээ. Үүнд:

- 1 дүгээр багц ажил – Ерөнхий төлөвлөлт буюу гарааны тайлан, эмнэлгийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөлт, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад 130,681.41 евро (анхны гэрээ 124,297,05 евро + нэмэлт гэрээ 6,384.36 евро),
- 2 дугаар багц ажил – ажлын даалгавар боловсруулах, тайланд зөвлөмж өгөх, тоног төхөөрөмжид тавигдах техникийн үзүүлэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендерийн баримт бичгийг боловсруулахад 155,371,32 евро,
- 3 дугаар багц ажил – техникийн туслалцаа үзүүлэх (ажлын зураг төсөлд техникийн үнэлгээ хийх болон гэрээний нөхцөлүүдийг тохиролцоход туслах)-д 31,074.26 евро.

1.21. АХБ-наас гэрээний дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Нидерланд Улсын “Simed International B.V” компанид 3 удаагийн шилжүүлгээр нийт 286,052.73 евро буюу 363,022.61 ам.долларыг олгосон байна.

Хүснэгт 4. Зөвлөх үйлчилгээнд олгосон санхүүжилт, мөнгөн дүнгээр

Д/д	Ажлын нэр	Гэрээний дүн /Евро/	Гарсан санхүүжилт		Огноо	Үлдэгдэл
			Евро	Доллар		
1	Ерөнхий төлөвлөлт	130,681.41	124,297.05 6,384.36	160,343.15 7,999.54	2014.09.23 2014.11.12	0
2	Ерөнхий төлөвлөлтийн үр дүнд хийгдэх ажлууд	155,371.32	155,371.32	194,679.92	2014.11.18	0
3	Техникийн тусалцаа	31,074.26	0	0	0	31,074.26
Нийт дүн		317,126.99	286,052.73	363,022.61		31,074.26

Эх сурвалж: Төслийн нэгжийн 2014 оны санхүүгийн тайлан

1.22. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Нидерланд Улсын “Simed International B.V” компанийн зөвлөх Mr. Wim P.G.Heesbeen 2015 оны 5 дугаар сарын 06-ны өдөр тус компани дампуурсан тухай мэдэгдлийг Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 5 төслийн нэгжид ирүүлсэн байна.

1.23. Эрүүл мэнд, спортын яам (хуучин нэрээр)-наас АХБ-нд Нидерланд Улсын “Simed International B.V” компанитай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээг цуцлах хүсэлтийг 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хүргүүлж, тус банкнаас гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй гэсэн хариуг 2015 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хүлээн авсан байна.

1.24. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 5 төслийн нэгжээс зөвлөх үйлчилгээний гэрээг цуцалсан тухай мэдэгдлийг Нидерланд Улсын “Simed International B.V” компанийн өмгөөлөгч Van Riet-д 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн байна.

1.25. Төслийн нэгж, Нидерланд Улсын “Simed International B.V” компанитай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний үлдэгдэл ажил болон барилгын зураг төслийг хүлээлцэх үед мэргэжлийн зөвлөмж авах зорилгоор Олон Улсын зөвлөх Mr. Mark Wijnmaalen-тай 20,000.0 ам.долларын гэрээг 2015 оны 8 дугаар сарын 06-ны өдөр, зөвлөх О.Саранцацралтай 7,000.0 ам.долларын гэрээг 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр тус тус байгуулжээ.

1.26. АХБ гэрээний дагуу Олон Улсын зөвлөх Mr. Mark Wijnmaalen-д 18,660.89 ам.доллар, зөвлөх О.Саранцацралд 7,000.0 ам долларыг олгосон бөгөөд зөвлөхүүд 2015 оны 9 дүгээр сарын 03, 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрүүдэд зураг төсөлд хяналт хийсэн тайланг Төслийн нэгжид хүргүүлсэн байна.

1.27. Зөвлөхүүдийн тайланд Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын зураг төсөл Нидерланд Улсын “Simed International B.V” компанийн өгсөн ажлын даалгавраас барилгын эзлэхүүн ойролцоогоор 35 хувь, ажлын талбай 10 хувиар ихэссэн талаар дурдсан байна.

1.28. Барилга угсралтын ажлын зураг төслийг анх төлөвлөснөөс ихэсгэж зурсан нь ирээдүйд ашиглалтын зардал өндөр гарах, улсын төсөвт ачаалал үзүүлэх эрсдэлийг дагуулж байна.

1.29. Барилгын эх загвар зураг /эскиз/-ийг “Өрх” ХХК боловсруулж, Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн хот төлөвлөлтийн ерөнхий газар баталсан байна.

Инженер-геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд дүрэм, журмын дагуу олгогдсон байна

1.30. Нэгдсэн эмнэлгийн барилгын талбайн инженер-геологийн судалгааг барилгын инженер-хайгуулын үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний “Монгео-экотех” ХХК-нд гүйцэтгэж, захирал М.Мягмаржав /Доктор Ph.D./ ажлын тайланг баталгаажуулсан байна.

1.31. Тус тайланд өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэхэд элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс, шавранцар чигжээстэй сайр, сайрган хөрс тархсан, газар хөдлөлийн 8 баллын бүсэд хамаарсан, 6.0-10.0 метр гүнтэй өрөмдсөн цооногуудад хөрсний ус илрээгүй гэсэн дүгнэлт гаргаж, Барилгын хөгжлийн төвийн 2014 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн магадлалын дүгнэлтээр баталгаажсан байна.



1.32. Нэгдсэн эмнэлгийн барилгын цахилгаан, ус, дулаан хангамж, холбооны техникийн нөхцөлүүдийг холбогдох дүрэм, журмын дагуу авч, барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

Хүснэгт 5. Техникийн нөхцөл олгосон судалгаа

Техникийн нөхцөлийн төрлүүд	Олгосон огноо	Дугаар	Хүчин чадал	Олгосон байгууллага
Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл	2015.06.16	65/2015	2.0 МВт	Эрчим хүчний яамны ажлын хэсэг
	2017.06.21	1068/2017	-	“УБЦТС” ТӨХК
	2017.09.22	65с/2017/22	2000 кВт	Эрчим хүчний яамны ажлын хэсэг
	2018.07.02	111с/2018/82	3200 кВт	Эрчим хүчний яамны ажлын хэсэг
Ус хангамжийн техникийн нөхцөл	2015.05.21	199/15		Ус сувгийн удирдах газар
Дулаан хангамжийн техникийн нөхцөл	2017.08.04	17/2017	3.42 Гкал/цаг	Эрчим хүчний яам
Холбооны техникийн нөхцөл	2015.07.07	ТН-С352/2015		“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК

Эх сурвалж: Холбогдох байгууллагаас батлагдсан техникийн нөхцөл

Зураг төсөл зохиогч барилгын бүтээцийн угсралтын ажлын зургийг орхигдуулснаас барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэхэд бэрхшээл үүссэн байна

1.33. Нэгдсэн эмнэлгийн барилгын зураг төслийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгох зөвлөх үйлчилгээний тендерийг Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан 2932-MON (SF) дугаар зээлийн гэрээний 4 дүгээр хавсралтын 1²-д заасны дагуу 2013 оны 3 дугаар сард баталсан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам”-ын хүрээнд зохион байгуулсан байна.

1.34. Эрүүл мэнд, спортын яам (хуучин нэрээр)-ны ТНБД-ын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 331 дүгээр тушаалаар Нэгдсэн эмнэлгийн төлөвлөлт, барилгын зураг төслийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

1.35. Үнэлгээний хороо тендерийн урилгыг АХБ-ны цахим хуудсанд 2014 оны 7 дугаар сарын 04-ний өдөр нийтэлсэн бөгөөд тендерт оролцогчдын хүсэлтийг 2014 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн дотор хүлээн авахаар тусгасан байна.

1.36. Тендерийг нээхэд 9 компани тендерт оролцох хүсэлт ирүүлснийг дэлгэрэнгүй жагсаалтаар гаргаж, Үнэлгээний хороо 2008 онд АХБ-наас гаргасан гарын авлагын дагуу үнэлгээг хийж, 70 буюу дунджаас дээш оноо авсан дор дурдсан 5 компанийг шалгаруулан богино жагсаалтад оруулж, тендерийн баримт бичгийг хүргүүлсэн байна. Үүнд:

- “Марс констракшн” ХХК,
- “Archetype group – Hong Kong” ХХК, “Archetype Mongolia” ХХК-ийн түншлэл,
- “Junglim Architecture” ХХК, ЭЗТ ХХК-ийн түншлэл,
- “SCG Consulting” ХХК, “Өрх” ХХК, “Aum & Lee Architects & Associates” ХХК-ийн түншлэл,
- “Casa Solo Arquitectos Slp” ХХК, Татах хүч ХХК-ийн түншлэл

Хүснэгт 6. Тендерт оролцох хүсэлтийг үнэлсэн судалгаа, оноогоор

Д/д	Шалгуур Компанийн нэр	Удирдлагын чадавх		Техникийн чадавх		Бүс нутаг дахь ажлын туршлага		Нийт дүн
		Бие даасан	Түншлэл	Бие даасан	Түншлэл	Бие даасан	Түншлэл	
1	“Марс констракшн” ХХК	15.5		45.5		15.5		76.50
2	“Archetype group, Hong Kong “Аркитип Монголия” ХХК		15.75		50.0		16.0	81.75
3	Building Design Authority, Nepal	14.25		40.0		13.5		67.75
4	“Криетив Монголия” ХХК	14.0		40.0		14.0		68.00
5	Junglim Architecture Co., Ltd. Korea “ЭЗТ” ХХК		15.75		47.25		17.0	80.00

² Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийт бараа таваар, ажил болон зөвлөх үйлчилгээ нь Худалдан авах ажиллагааны болон Зөвлөх үйлчилгээний журмын дагуу тус тус хийгдэнэ.



6	Resources Development Consultants Ltd, Sri Lanka	14.25		41.5		13.25		69.00
7	“SCG Consulting” ХХК							
	“Өрх” ХХК Aum & Lee Architects & Associates Korea		14.75		44.5		14.5	73.75
8	South Asia Management and Engineering Services (Sames) Pvt. Ltd, Bangladesh	13.0		37.75		13.5		64.25
9	Casa Solo Arquitectos Slp, Spain							
	“Татах хүч” ХХК		15.5		43.75		15.1	74.35

Эх сурвалж: Төслийн нэгжийн худалдан авах ажиллагааны материал

1.37. Үнэлгээний хороонд богино жагсаалтад орсон “Өрх” ХХК ашиг сонирхлын зөрчилтэй тул тус компанийн ирүүлсэн техникийн саналаас татгалзан санхүүгийн саналыг нээхгүй буцаах зөвлөмжийг АХБ-ны 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн байна.

1.38. Төслийн нэгжид “Casa Solo Arquitectos Slp” компани 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдөр, “Марс констракшн” ХХК 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр тендерт оролцохоос татгалзсан тухай мэдэгдлийг албан бичгээр ирүүлсэн байна.

1.39. Үнэлгээний хороо богино жагсаалтад үлдсэн “Archetype group” болон “Junglim Architecture” компаниудын техникийн болон санхүүгийн саналыг үнэлэхэд “Junglim Architecture” компани 945.56 буюу хамгийн өндөр оноог авч, нэгдүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 7. Тендерт оролцогчдыг үнэлсэн судалгаа, оноогоор

Компанийн нэр	Техникийн саналын			Санхүүгийн саналын			Нийт үнэлгээ
	Үнэлгээ	Хувийн жин	Оноо	Үнэлгээ	Хувийн жин	Оноо	
	1	2	1*2=3	4	5	4*5=6	
Archetype group	791.70	0.8	633.36	921.35	0.2	184.27	817.63
Junglim Architecture Co., Ltd	931.95	0.8	745.56	1,000.00	0.2	200.00	945.56
ЭЗТ ХХК							

Эх сурвалж: Төслийн нэгжийн худалдан авах ажиллагааны баримт материал

1.40. Эрүүл мэнд, спортын яам (хуучин нэрээр) 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдөр “Junglim Architecture” болон “ЭЗТ” ХХК-ийн консорциумтай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах тухай хэлэлцээр хийж, 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдөр ажлыг эхэлж, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах хугацаатай 551,540.0 ам.долларын гэрээг 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдөр байгуулж, гарын үсэг зурсан бөгөөд тус гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулж, гэрээний дүнг 741,948.52 ам.доллар болгон нэмэгдүүлсэн байна. Үүнд:

- Гадна дулаан, цахилгаан, холбоо, ус хангамж болон ариутгах татуурга, байр зүйн зурагтай холбоотой зардлыг орхигдуулснаас зөвлөхийн цалингийн 25,405.60 ам.долларын нэмэлт зардал гарсан тул 2015 оны 8 дугаар сарын 15-ны өдөр гэрээний дүнг 576,945.60 ам.доллар болгосон.
- Эрүүл мэндийн яам, барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Vamed engineering” ХХК-тай 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан LW1 дугаар гэрээнд зохиогчийн хяналтын зардлыг 165,697.49 ам.доллаароор тусгасан, барилга шилжсэнтэй холбогдон нэмэлт зардал гарсан зэргээс шалтгаалан зохиогчийн хяналтын зардалд 108,002.92 ам.доллар, нэмэлт ажилд 57,000.0 ам.доллар зарцуулахаар тооцож, 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр гэрээний дүнг нэмэгдүүлж, нийт 741,948.52 ам.доллар болгосон.

1.41. “Junglim Architecture” компанитай консорциумаар орсон “ЭЗТ” ХХК 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдөр гэрээгээр хүлээсэн үүргээ “Бьюлдингс технолоджи” ХХК-нд шилжүүлсэн байна.

1.42. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээнд “Junglim Architecture” болон “Бьюлдингс технолоджи” ХХК-ийн консорциумаар дараах 4 үе шаттай ажлыг 741,948.52 ам.доллаароор гүйцэтгүүлэхээр тусгажээ. Үүнд:

- 1 дүгээр үе шатанд – Схем зураг боловсруулах ажлыг 110,308.0 ам.доллар,
- 2 дугаар үе шатанд – Ажлын зургийг 350,553.92 ам.доллар,
- 3 дугаар үе шатанд – Тендерийн баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд 115,389.12 ам.доллар,

- 4 дүгээр үе шатанд – Зохиогчийн хяналт хийхэд 165,697.48 ам.доллар.

1.43. АХБ-наас “Junglim Architecture” болон “Бьюлдингс технолоджи” ХХК-ийн консорциумд нийт 7 удаагийн шилжүүлгээр 657,772.92 ам.долларыг олгожээ.

Хүснэгт 8. Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид олгосон санхүүжилтийн гүйцэтгэл, ам.доллаароор

Д/д	Ажлын нэр	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Огноо	Үлдэгдэл
1	Схем зураг боловсруулах	110,308.00	110,308.00	2015.06.16	0
2	Ажлын зураг хийх	350,553.92	293,553.92 34,739.31 22,260.69	2015.12.15 2018.05.02 2018.05.03	0
3	Тендерийн баримт бичиг боловсруулах	115,389.12	115,389.12	2016.12.08	0
4	Зохиогчийн хяналт	165,697.48	39,787.71 41,734.57	2018.05.02 2018.10.23	84,175.60
Нийт дүн		741,948.52	657,772.92		84,175.60

Эх сурвалж: Төслийн нэгжийн санхүүгийн баримт материал

1.44. Нэгдсэн эмнэлгийн барилгын зураг төслийг “Junglim Architecture” ХХК боловсруулж, орчуулга, баталгаажуулалтын ажлыг “Бьюлдингс технолоджи” ХХК гүйцэтгэсэн бөгөөд зураг төсөлд 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Барилгын хөгжлийн төв магадлал хийж, 2015 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 1061/2015 дугаар магадлалын ерөнхий дүгнэлт гарсан байна.

1.45. “Junglim Architecture” болон “Бьюлдингс технолоджи” ХХК-ийн консорциум барилгын зураг төслийг 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдөр захиалагчид хүлээлгэн өгсөн боловч барилга бүтээцийн угсралтын ажлын зураг төслийг Монгол Улсын Барилгын норм ба дүрмийн дагуу гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Олон Улсын стандартын дагуу альбомоор кодолсон нь манай улсад мөрдөгдөж буй барилгын норм ба дүрэмд нийцэхгүй байна.

1.46. Энэ нь төсөл хэрэгжүүлэх нэгжид мэргэжлийн шаардлага хангасан мэргэжилтнийг ажиллуулаагүй, зураг төслийг хүлээлцэхэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй гэрээт ажилтан бөгөөд Олон Улсын зөвлөх Mark Wijnmaalen, зөвлөх О.Саранцацрал нар дээрх асуудлаар мэргэжлийн зөвлөмжийг ажлын тайлангаар өгөөгүйгээс шалтгаалж барилга угсралтын ажлыг эхлүүлж, үргэлжлүүлэхэд бэрхшээл үүсгэсэн байна.

1.47. Иймд барилга угсралтын ажлыг эхлүүлж, үргэлжлүүлэхийн тулд барилгын суурийн ажлын зургийг “Ган харш” ХХК 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдөр гүйцэтгэж, сууриас дээш давхрын ажлын зургийг зураг төслийг гүйцэтгэгч “Бьюлдингс технолоджи” ХХК 2017 оны 7 дугаар сараас эхлэн гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар 2018 оны 6 дугаар сард оруулж баталгаажуулсан байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү)

1.48. Зураг төсөл зохиогч “Бьюлдингс технолоджи” ХХК ажилдаа хариуцлагагүй хандсанаас шалтгаалан магадлалаар баталгаажсан барилга угсралтын ажлын зурагт дараах ажлууд буруу болон дутуу зурагдсан байна. Тухайлбал,

- Материалын түүвэр дутуу хийгдсэн, түүвэрт арматурын хэмжээг буруу бичсэн,
- 1 болон 2 дугаар давхрын өрөөний хуваалт болон ерөнхий план зургийг бүрэн гаргаагүй,
- Ажлын нарийвчилсан зураг байхгүй,
- Барилга архитектурын зурагт багаж ариутгал, гал тогоо, лаборатори, эмийн сангийн хэсгүүдийн технологийн урсгалыг буруу зурсан,
- Ханын зохион байгуулалтад материалын төрлөөр өрөөнүүдийг ялгаж ангилаагүй,
- Гадна хана, цоколь, галын хана, зоорины давхрын шат, хэв гажилтын гипсэн хана, заадасны босоо болон хэвтээ хэсэглэл зурагдаагүй байна.

Барилгын зураг төслийн цахилгаан хангамжийн хэсгийг барилгын норм ба дүрмийн дагуу зураагүйгээс зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн байна

1.49. Зураг төсөл зохиогч “Junglim Architecture”, “Бьюлдингс технолоджи” ХХК-ийн консорциум болон зураг төсөлд магадлал хийсэн Барилгын хөгжлийн төвийн хариуцлагагүй байдлаас шалтгаалан Монгол Улсын хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан барилгын норм ба дүрмийг зөрчин цахилгаан хангамжийн 10/0.4 кВ-

ын дэд өртөө, дизель станц, даралтад сав, тоног төхөөрөмжийг үндсэн барилгын зоорины давхарт байрлуулахаар төлөвлөж зурсан байна.

1.50. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдөр хийсэн хяналт шалгалтаар дээрх зөрчил илэрч, Эрчим хүчний тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан “Цахилгаан байгууламжийн дүрэм” БД 43-101-03-ийн 6.2.6, 6.2.7 дахь заалт, Түлш эрчим хүчний сайдын 2007 оны 93 дугаар тушаалаар баталсан “Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ажиллах дүрэм”-ийн 6.1.1, 6.1.2, 6.1.3 дахь заалтыг тус тус зөрчсөн тул ажлын зураг төслийг өөрчилж, үндсэн барилгын зоорины давхраас тусад нь буюу зориулалтын барилгад холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөж, угсралт суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэх нь зүйтэй гэж зөвлөсөн байна.

1.51. Барилгын гадна цахилгаан хангамжийн кабелийн трасс өөрчлөгдөж, дотор цахилгаан хангамжийн 10/04 кВ-ын дэд өртөө, дизель цахилгаан станц, даралтат хийн байгууламжийг барих ажлууд зураг, төсөв байхгүйгээс шалтгаалан зогссон бөгөөд Төслийн нэгж 2019 оны 4 дүгээр сарын байдлаар дэд өртөөний барилгын зураг төслийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлахаар ажиллаж байна.

Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын төсвийг зургаас зөрүүтэй тооцсоноос төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн байна

1.52. Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын зураг төсвийг 2015 онд “Зураг төсөл консалтинг” ХХК-ийн тэргүүлэх төсөвчин Б.Норовсүрэн хийж, эксперт А.Эрдэнэчимэг 33,562.3 сая төгрөгөөр хянаж, Барилгын хөгжлийн төв 2015 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1061/2015 дугаар, 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 268/2016 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

1.53. Барилга угсралтын ажлын төсвийг “Junglim Architecture” компанийн боловсруулсан ажлын зураг болон ажлын тоо хэмжээнд үндэслэн хийжээ.

1.54. Барилга угсралтын ажлын төсвийг хийх үед бүтээцийн угсралтын ажлын зураг дутуу, зарим ажлын тоо хэмжээ зургаас зөрүүтэй байснаас шалтгаалан барилга угсралтын ажлын зургаас зөрүүтэй төсөв хийгдсэн нь Нэгдсэн эмнэлгийн барилгын төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг үүсгэжээ.

1.55. Дутуу орхигдсон барилга бүтээцийн угсралтын ажлын зургийг 2018 онд зохиогч “Бьюлдингс технолоджи” ХХК боловсруулж, эксперт хянасан тул захиалагч Эрүүл мэндийн яам богино хугацаанд зураг төсөл зохиогч компаниар барилга угсралтын ажлын нэгдсэн төсвийг хийлгэж, магадлалаар оруулах шаардлагатай байна.

Барилгын хөгжлийн төвийн хянасан төсвөөс тендерт шалгарсан төсөв 9.8 тэрбум төгрөгөөр илүү байна

1.56. Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалт нь Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан 2932-MON (SF) дугаар зээлийн гэрээний 4 дүгээр хавсралтын 1³-д заасны дагуу 2015 оны 4 дүгээр сард баталсан “Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу зохион байгуулагдсан байна.

1.57. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасны дагуу захиалагчийг төлөөлж Эрүүл мэнд, спортын яам (хуучин нэрээр)-ны ТНБД-ын 2015 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар тушаалаар “Сонгинохайрхан дүүргийн жишиг Нэгдсэн эмнэлгийн барилга угсралт, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. (Тус үнэлгээний хороо тендерийн материал нээснээс хойш үнэлгээ хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хүртэл хугацаанд ажилласан)

³ Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийт бараа таваар, ажил болон зөвлөх үйлчилгээ нь Худалдан авах ажиллагааны болон Зөвлөх үйлчилгээний журмын дагуу тус тус хийгдэнэ.

1.58. Захиалагч Нэгдсэн эмнэлгийн барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулснаас хойш үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг дараах байдлаар 4 удаа өөрчилж, шинэчилсэн байна.

Хүснэгт 9. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүд

Д/д	Тушаалын нэр	Тушаал гаргасан холбогдох албан тушаалтны нэр	Тушаалын огноо	Тушаалын дугаар	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний тоо
1	Үнэлгээний хороо байгуулах тухай	ТНБД С.Ламбаа	2015.01.04	02	11
2	Үнэлгээний хороо байгуулах тухай	ТНБД С.Ламбаа	2016.03.04	65	11
3	Үнэлгээний хороонд өөрчлөлт оруулах тухай	ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюунчимэг	2016.05.27	Б/174	Өмнөх бүрэлдэхүүний 1 гишүүн солигдсон
4	Үнэлгээний хороо байгуулах тухай	ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Бат-Эрдэнэ	2016.11.25	453	9
5	Үнэлгээний хороо байгуулах тухай	ТНБД Д.Очирбат	2016.12.05	А/103	11

Эх сурвалж: Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал

1.59. Захиалагч үнэлгээний хороог байгуулах, бүрэлдэхүүнийг өөрчлөх, шинэчлэн байгуулах зэргээр тушаал гаргахад 1 жил 11 сарын хугацаа зарцуулсан нь Эрүүл мэнд, спортын яам (хуучин нэрээр)-ны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн, тогтвортой ажиллаагүй зэргээс шалтгаалсан бөгөөд энэ нь төсөл хэрэгжих хугацаа удаашрахад хүргэсэн байна.

1.60. Эрүүл мэндийн яамны ТНБД-ын 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 453 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо “Junglim Architecture” компанийн боловсруулсан тендерийн баримт бичгийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. (Тус үнэлгээний хороо нь тендерийн материал нээх хүртэл хугацаанд ажилласан)

1.61. “Junglim Architecture” компани тендерийн баримт бичгийг үйлдэхдээ тендер зарласан ажлын тоо хэмжээг ажлын зургаас зөрүүтэй боловсруулснаас шалтгаалан барилга угсралтын ажлын явцад тендерийн тоо хэмжээнд тусгагдаагүй ажил гарснаас төсөвт өртөг нэмэгдэх нөхцөл бүрдсэн байна.

1.62. Төслийн нэгжээс АХБ-нд Нэгдсэн эмнэлгийн барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлах хүсэлтийг 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 46 дугаар албан бичгээр хүргүүлж, тендер зарлах зөвшөөрлийг 2016 оны 7 дугаар сарын 06-ны өдөр авсан байна.

1.63. Үнэлгээний хороо тендерийн урилгыг дор дурдсан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлж, тендерийн өмнөх уулзалтыг 2016 оны 7 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, тендерт ирүүлэх материалыг 2016 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 15:00 цагийн дотор хүлээн авахаар тусгасан байна. Үүнд:

- “Өдрийн сонин”-ы 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 160 (5425) дугаарт,
- “Өнөөдөр” сонины 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн дугаарын В5 дугаар талд,
- 2016 оны 7 дугаар сарын 07-ны өдөр АХБ-ны цахим хуудсанд.

1.64. Тендерийн урилга нийтэлснээс хойш 24 компани тендерийн баримт бичгийг худалдан авсан бөгөөд тендерийн өмнөх уулзалтад 18 компанийн төлөөлөл оролцжээ.

1.65. Үнэлгээний хороо тендерийн нээлтийг 2016 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 15:00 цагт зохион байгуулахад “Vamed engineering” ХХК, “Su Qian Jing Hang” ХХК, “Моннис” ХХК болон “Тэрмигас” ХХК-ийн консорциум гэсэн 3 компани тендерт оролцох хүсэлт ирүүлсэн байна.

1.66. Тендерт оролцох хүсэлт ирүүлсэн 3 компанийн санхүүгийн саналыг Барилгын хөгжлийн төвийн хянасан төсөвтэй харьцуулбал:

Дүрслэл 1. Барилгын хөгжлийн төвийн хянасан төсөв болон тендерт ирүүлсэн саналын харьцуулсан судалгаа, мянган ам.доллар



Эх сурвалж: Эрүүл мэндийн яаманд компаниудын ирүүлсэн тендерийн материал

1.67. Барилгын хөгжлийн төвийн хянасан барилга угсралтын ажлын төсвөөс тендерт оролцогч компаниудын ирүүлсэн санхүүгийн санал 14.6-36.8 хувиар өндөр байгаа нь тендер зарласан ажлын тоо хэмжээнд хийгдэх ажлыг хяналтын төсвийн дүнгээс өндрөөр хийхээр санал өгснийг харуулж байна.

1.68. Үнэлгээний хорооны 2017 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн шийдвэрээр Нэгдсэн эмнэлгийн барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгох шалгаруулах тендерт Австри Улсын “Vamed engineering” ХХК-ийг шалгаруулсан бөгөөд АХБ-наас тус компанитай гэрээ байгуулах зөвшөөрлийг 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр олгосон байна.

1.69. Эрүүл мэндийн яамны 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 2/129 дугаар албан бичгээр “Vamed engineering” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн байна.

1.70. Мэдэгдэлд дурдсаны дагуу “Vamed engineering” ХХК 28 хоногийн дотор Худалдаа хөгжлийн банканд 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 2,480.0 мянган ам.долларын гүйцэтгэлийн баталгааг байршуулж, 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Эрүүл мэндийн яамтай Нэгдсэн эмнэлгийн барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулах ажил гүйцэтгэх 24,800.0 мянган ам.долларын гэрээг байгуулсан байна.

1.71. Барилгын хөгжлийн төвийн хянасан барилга угсралтын ажлын төсөв 15,470.5 мянган ам.доллар буюу 33,562.3 сая төгрөг (Монголбанкны 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн ам.долларын хаалтын ханш 1 USD=MNT 2169.44 төгрөгөөр тооцов), АХБ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан барилга угсралтын ажлын явцад суурилагдах тоног төхөөрөмжийн дүн 3,900.0 мянган ам.доллар буюу 8,460.8 сая төгрөг байхад тендерт шалгарсан “Vamed engineering” ХХК-ийн барилга угсралтын ажлын төсөв 20,000.0 мянган ам.доллар буюу 43,388.8 сая төгрөг, барилга угсралтын ажлын явцад суурилагдах тоног төхөөрөмжийн төсөв 4,800.0 мянган ам.доллар буюу 10,413.3 сая төгрөг байгаа нь хяналтын төсвөөс тендерт шалгарсан төсөв нийт 5,429.5 мянган ам.доллар буюу 11,779.0 сая төгрөгөөр илүү байгаа нь материалын үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

1.72. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтад оролцсон “Моннис” ХХК, “Тэрмигас” ХХК-ийн консорциум, “Su Qian Jing Hang Construction” ХХК-ыг дараах шалтгаанаар тендерт шалгаруулаагүй байна. (Хүснэгт 10-т харуулав)

Хүснэгт 10. Тендерт оролцсон компанийн шалгараагүй шалтгаан

Компанийн нэр	Шалгаруулаагүй шалтгаан
1 “Моннис” ХХК, “Тэрмигас” ХХК-ийн консорциум	Ижил төстэй ажил хийсэн ажлын туршлагыг бүрэн хангаагүй, 1.034 сая ам.долларын өртөг бүхий 188 төрлийн салхивч, агааржуулалтын ажлыг үнэлээгүй орхигдуулсан, зарим тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг ирүүлээгүй, барилгын зарим машин механизмын гэрчилгээний хуулбар болон нотлох баримт ирүүлээгүй, зарим нэр төрлийн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, брошюр, катологи ирүүлээгүй байна.



2	“Su Qian Jing Hang Construction” ХХК	Ижил төстэй ажил хийсэн ажлын туршлагыг бүрэн хангаагүй, хяналтын төсвөөр тооцоолсон ажлын тоо хэмжээнд 1.9 сая ам.долларын өртөг бүхий 326 төрлийн ажлыг үнэлээгүй, зарим тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг ирүүлээгүй, мөн зарим тоног төхөөрөмжийн загвар тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод зааснаас зөрсөн байна.
---	--------------------------------------	---

Нэгдсэн эмнэлэг барих төслийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааны үе шатанд 4 жил 3 сарын хугацааг зарцуулжээ

1.73. Нэгдсэн эмнэлэг барих төсөл Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан зээлийн гэрээгээр хэрэгжсэн бөгөөд барилга угсралтын ажлыг 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр дуусгаж, хүлээлгэн өгөхөөр байна.

1.74. Гэрээнд заасан хугацааг төслийг хэрэгжүүлэх үе шатаар ангилж үзэхэд төлөвлөлт буюу холбогдох ажлын зөвшөөрөл авах, зураг төсөл боловсруулж батлуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үе шатанд 4 жил 3 сар, барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд 2 жил 8 сарын хугацааг тус тус зарцуулахаар байна.

Хүснэгт 11. Төсөл хэрэгжүүлэх үе шатанд зарцуулах хугацаа, жил, сараар

Д/д	Үйл ажиллагааны нэр	Батлагдсан огноо	Зарцуулсан хоног
Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны үе шат			
1	Зээлийн гэрээ байгуулагдсан	2013.02.07	
2	Барилгын зураг төсөл магадлалаар батлагдсан	2015.10.09	4 жил 3 сар
3	Тендерийн урилга нийтэлсэн	2016.07.08	
4	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан	2017.05.24	
Барилга угсралтын ажил			
1	Гэрээ дуусах хугацаа	2020.01.30	2 жил 8 сар

Эх сурвалж: Батлагдсан баримт бичиг

1.75. Эрүүл мэндийн яам Нэгдсэн эмнэлгийн барилга төслийг анх төлөвлөхдөө иж бүрэн батлагдсан зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлаагүй, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг холбогдох төрийн болон аж ахуйн нэгжийн түвшинд хугацаа алдахгүй, оновчтой зохион байгуулаагүйгээс шалтгаалан тус төслийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааны үе шатанд 4 жил 3 сарын хугацаа зарцуулсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ҮҮСЭЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭЖ, ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААНД ДУУСГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Ажил гүйцэтгэх гэрээг FIDIC загвараар байгуулснаас ажлын тоо хэмжээ, өртөгт өөрчлөлт орох эрсдэлтэй байна

2.1. Эрүүл мэндийн яам, “Vamed engineering” ХХК-тай 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 730 хоногийн хугацаанд үргэлжлэх 24.8 сая ам.долларын дүнтэй “Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулах ажил” гүйцэтгэх гэрээг байгуулжээ.

2.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичигт дээрх ажлыг гүйцэтгэх гэрээний загварыг боловсруулахдаа Зөвлөх инженерүүдийн Олон Улсын холбооноос гаргасан (Fédération internationale Des Ingénieurs-Conseils) FIDIC гэрээний загварыг ашигласан бөгөөд ягаан номын дагуу барилгын зураг төсөл, угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр тусгасан байна.

2.3. Ягаан номын онцлог нь барилгын зураг төслийг захиалагч хийлгэж, төлбөрийг дахин хэмжилтэд үндэслэн гүйцэтгэх (Ажил гүйцэтгэх FIDIC гэрээний ерөнхий нөхцөлийн 13.1-т ажлын тоо хэмжээний зөрүүг, 13.8-т ажлын өртөгт гарах өөрчлөлтийн зохицуулалтыг тусгасан), барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг инженер хянах зохицуулалттай байна.

2.4. “Vamed engineering” ХХК-ийн тендерт шалгарсан төсвийг 2016 онд тэргүүлэх төсөвчин Г. Пэлээсүрэн 20.0 сая ам.доллар буюу 43,388.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр “Estimator pro” программаар тооцож гаргасан байна.

2.5. Ажил гүйцэтгэх FIDIC гэрээнд тусгагдсан ажлын тоо хэмжээ болон өртөг нь барилга угсралтын ажлын явцад өөрчлөгдөн гэрээний ерөнхий нөхцөлийн 13.1, 13.8-д заасан шаардлагыг хангаж, түүнийг захиалагчийн хяналтын инженер баталгаажуулсан тохиолдолд тус гэрээний дүн өөрчлөгдөх эрсдэлтэй байна.

2.6. Гэрээлэгч талууд 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээнд Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна” гэж заасныг үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулж, гэрээний хугацааг 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр дуусгахаар сунгалт хийжээ.

Ажлын үр дүнг ерөнхий гүйцэтгэгч бүрэн хариуцахаар байна

2.7. Ерөнхий гүйцэтгэгч “Vamed engineering” ХХК 2016 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр туслан гүйцэтгэгч “Сэтунари” ХХК болон “Магнус Сентурион Констракшн” ХХК-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчийн ажил үүргийн хуваарийг дараах байдлаар тусгасан байна.

Хүснэгт 12. Ерөнхий болон туслан гүйцэтгэгчийн ажил үүргийн хуваарь

Д/д	Компанийн нэр	Статус	Ажил үүргийн хуваарь
1	“Vamed engineering” ХХК	Ерөнхий гүйцэтгэгч	Эрүүл мэндийн байгууллагын төлөвлөлт дизайн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн зөвлөх үйлчилгээ, ханган нийлүүлэлт, суурилуулалт, эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн худалдан авалт, худалдан авалтын дараах үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний шийдлүүд, санхүүжилт өсөх асуудал. Тухайлбал, Төслийн хэрэгжилтийн явцад санхүүжилт шаардагдсан тохиолдолд зээлийн зохицуулалтыг хариуцан гүйцэтгэнэ.
2	“Сэтунари” ХХК	Туслан гүйцэтгэгч	“Сэтунари” ХХК нь Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалт болон борлуулалтын дараах үйлчилгээг үзүүлэх.
3	“Магнус Сентурион Констракшн” ХХК	Туслан гүйцэтгэгч	Барилга угсралт ажил, цахилгаан, дулаан, холбоо болон ариутгах татуургыг суурилуулах, дотоод засал, гадна тохижилт, барилгын дотоод болон дуусгалын ажлууд, байгаль орчныг хамгаалах төлөвлөлтүүд, байгаль орчинд халгүй эко байгууламжийг барих, зөвлөх үйлчилгээний төлөвлөлтийг гүйцэтгэнэ.

Эх сурвалж: Төслийн нэгжид ирүүлсэн компаниудын хооронд 2016 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан санамж бичиг

2.8. Санамж бичигт тусгасан болон хийсэн ажлын бодит гүйцэтгэлийг дүгнэхэд барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгч Vamed engineering ХХК-ийн гадаадын харьяат 9, Монгол Улсын харьяат 22 инженер, техникийн ажилтнуудын удирдлага, зааварчилгааны дагуу туслан гүйцэтгэгч компаниар барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлсэн байна.

2.9. Ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчтэй 2017 оны 8 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан “Туслан гүйцэтгэх гэрээ”-ний 1.9, 1.10-т “Ерөнхий гүйцэтгэгч нь барилга угсралт, тоног төхөөрөмж нийлүүлэлт, үйлчилгээний туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүнд, түүнтэй холбоотой гарах үр дагаврыг захиалагчийн өмнө бүрэн хариуцах ба Монгол Улсын Барилгын тухай хуульд заасан барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг болон төслийн баримт бичигт заасан нөхцөл шаардлагын дагуу эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, баталгаат хугацааны үйлчилгээтэй холбоотой чиг үүргийг захиалагчийн өмнө бүрэн хүлээнэ” гэж заасан байна.

Эрүүл мэндийн яам төслийн нэмэлт санхүүжилтийн хэлэлцээр байгуулаагүй байхад нэмэлт ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, 3.9 сая ам.долларын санхүүжилтийг олгуулсан байна

2.10. Эрүүл мэндийн яам, ерөнхий гүйцэтгэгч “Vamed engineering” ХХК-тай 24.8 сая ам.долларын гэрээ 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан боловч барилга угсралтын ажлыг гэрээ байгуулснаас хойш 3 сарын дараа буюу 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр эхэлсэн байна.

2.11. Энэ нь барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2017 оны 8 дугаар сарын 01-ний өдөр олгосонтой холбоотой байна.

2.12. Гэрээний нийт дүнгийн 80.6 хувь буюу 20.0 сая ам долларыг барилга угсралтын ажилд, 19.4 хувь буюу 4.8 сая ам.долларыг тоног төхөөрөмж суурилуулах ажилд зарцуулагдана.

2.13. Гүйцэтгэгчид гэрээний дагуу барилга угсралтын ажлын гүйцэтгэл (5 дахь ажлын гүйцэтгэлийг оруулаагүй)-ээр 4 удаа нийт 12.1 сая ам.доллар буюу гэрээгээр олгох нийт санхүүжилтийн 60.5 хувийг олгожээ.

Хүснэгт 13. Гүйцэтгэгч компанид олгосон санхүүжилтийн мэдээлэл

Д/д	Ажлын гүйцэтгэл	Эрх зүйн үндэслэл	Санхүүжилт олгосон огноо	Олгосон санхүүжилтийн дүн		Тооцсон ханш 1\$=₮
				Ам.доллар	Төгөрөг	
1	Урьдчилгаа төлбөр	Гэрээний ТН-ийн 14.1, 14.2 дагуу	2017.06.30	2,000,002.0	4,698,424,698.42	2017.06.29 2,349.21
2	Ажлын гүйцэтгэл 1 (IPC 1)	Гэрээний дагуу	2017.12.14	3,000,000.0	7,308,810,000.0	2017.12.13 2,436.27
			2018.01.12	1,403,997.7	3,416,867,082.56	2018.01.11 2,433.67
3	Ажлын гүйцэтгэл 2 (IPC 2)	Гэрээний дагуу	2018.08.13	2,493,565.68	6,124,172,374.42	2018.08.12 2,455.99
4	Ажлын гүйцэтгэл 3 (IPC 3)	Гэрээний дагуу	2018.08.13	1,492,217.54	3,664,871,356.06	2018.08.12 2,455.99
5	Ажлын гүйцэтгэл 4 (IPC 4)	Гэрээний дагуу	2018.12.06	1,717,677.05	4,524,687,708.34	2018.12.05 2,634.19
6	Ажлын гүйцэтгэл 5 (IPC 5)	Гэрээний 4.2, 12.3, 13.1 дэх заалт	2018.12.17	3,882,745.01	10,230,994,273.90	2018.12.16 2,634.99
Нийт дүн				15,990,204.98	39,968,827,493.5	

Эх сурвалж: Төслийн нэгжийн 2017, 2018 оны санхүүгийн тайлан

2.14. Барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл 2019 оны 4 дүгээр сарын байдлаар 54.4 хувьтай байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү)

2.15. Тендер зарлах ажлын тоо хэмжээг боловсруулах үүрэгтэй “Junglim Architecture” ХХК гүйцэтгэх ажлын тоо хэмжээг барилгын зургаас зөрүүтэй боловсруулж, Эрүүл мэндийн яаманд хүлээлгэн өгснөөс шалтгаалан төсөвт өртөг нэмэгдэх үр дагавар бий болсон байна.

2.16. Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай тус төслийг хэрэгжүүлэх явцад гарсан нэмэлт зардлыг санхүүжүүлэх хэлэлцээр хийгээгүй байхад АХБ барилга угсралтын ажлын явцад гэрээгээр гүйцэтгэх ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлт ажил гарсныг 5 дахь ажлын гүйцэтгэлээр (Эрүүл мэндийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч НХОГ-ын дарга Б.Мөнхбат, Ерөнхий инженер Г.Цэрмаа нар) баталгаажуулж, 3.9 сая ам.доллар буюу 10.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ажил гүйцэтгэх гэрээ (FIDIC)-ний 4.2, 12.3, 13.1 дэх хэсгийг үндэслэсэн олгожээ.

Гадна зам талбайн тохижилт, авто машины зогсоол байгуулах ажлын зураг төсөл боловсруулагдах шатанд байна

2.17. Монгол Улсын Засгийн газар, АХБ-тай 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний 5 дугаар хавсралтын 10 дахь хэсэгт “Эрүүл мэндийн яам, Нийслэлийн ЗДТГ-аар дамжуулан зээлдэгч шинэ нэгдсэн эмнэлгийн барилгыг барьж дууссаны дараа одоо байгаа Сонгинохайрхан дүүргийн эмнэлгийн барилгыг нурааж улмаар төслийн хүрээнд авч ажиллуулсан зураг төслийн компанийн боловсруулсан нарийвчилсан зураг төслийн дагуу хангалттай хэмжээний машины зогсоол, ногоон байгууламжийг барих боломжийг бүрдүүлнэ” гэж заасан боловч Сангийн сайдад Нийслэлийн Засаг даргаас “Дэмжлэг хүсэх тухай” 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүргүүлсэн 02-03/4748 дугаар албан бичигт дараах саналыг тусгасан байна. Үүнд:

- Сонгинохайрхан дүүргийн хүн амын тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 322,458 болон өссөн бөгөөд нийслэлийн нийт хүн амын 22.8 хувь нь тус дүүрэгт амьдардаг,
- Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөл тогтвортой буураагүй, эмнэлгийн ачаалал жилээс жилд нэмэгдэж байгаа тул одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа 1982 онд ашиглалтад орсон эмнэлгийн барилгыг цаашид нураахгүй хэвээр үлдээж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр үргэлжлүүлэн ашиглах саналтай байна гэжээ.

2.18. Хуучин эмнэлгийн барилгыг буулгаж, гадна зам талбайн тохижилт, авто машины зогсоол барихаар төлөвлөсөн боловч тус барилгыг буулгахгүй цаашид ашиглахаар шийдвэрлэснээс шалтгаалж захиалагч дахин шинээр зураг төсөл хийлгэхээр холбогдох ажлын даалгаврыг бэлтгэсэн байна. Үүнд:

- Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд нийслэлийн хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөний газраас 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдөр баталсан МЗХ2019/04-04 дугаартай “Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар”,
- Нийслэлийн засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн 2019 оны 3 дугаар сарын 05-ны өдөр баталсан ЗД-19/013 дугаартай “Сонгинохайрхан дүүргийн 4, 19 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгээс Толгойтын гудамжтай холбогдох авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар”,
- Нийслэлийн засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн 2019 оны 3 дугаар сарын 05-ны өдөр баталсан ЗД-19/014 дугаартай “Сонгинохайрхан дүүргийн 4, 19 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгээс Толгойтын гудамжтай холбогдох авто зам дахь үерийн хамгаалалтын далан дээр баригдах гүүрний инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар”.

2.19. Зээлийн хэлэлцээр хийсний дараа Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өмнө гаргасан шийдвэрээ өөрчилснөөс шалтгаалан дээрх асуудал үүссэн бөгөөд одоогийн байдлаар ажлын даалгаврын дагуу гадна зам талбайн тохижилт, авто машины зогсоол хийх зураг төсөл боловсруулагдах шатанд байна.

Гүйцэтгэгчийн ирээдүйд хийх ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, 826.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгуулсан байна

2.20. Ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий нөхцөлийн 14.7-ын (В)-д “Инженер гэрээлэгчийн ажлын гүйцэтгэл, холбогдох баримт бичгийг хянан зөвшөөрсний дараа 56 хоногийн дотор гүйцэтгэлийн явцын төлбөрийг захиалагч шилжүүлэх үүрэгтэй” гэж заасан байна.

2.21. Гүйцэтгэгч Vamed engineering ХХК болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын инженерүүд 56 хоногийн дараа гүйцэтгэгчид

санхүүжилтийг олгох үед хийгдэж дууссан байх боломжтой ажлууд гэж үзэн ирээдүйд хийгдэх дараах ажлын санхүүжилтийг урьдчилан тооцож, баталгаажуулсан байна.

Хүснэгт 14. Санхүүжилт авсан ирээдүйд хийгдэх ажлын жагсаалт, мөнгөн дүнгээр

Д/д	Барилга байгууламж, ажлын нэр	Төсөвт өртөг	
		ам.доллар	төгрөг ⁴
1	Гадна цахилгааны ажил - 700 м	88,218.21	191,384,113.50
2	Дээвэрт 3 үе хар цаас наах - 7192 м2	173,398.46	376,177,555.06
3	Дотор бохир тоноглолын ажил	25,791.17	55,952,395.84
4	Хуваарилах самбарын ажил	77,805.78	168,794,971.36
5	Гэрэлтүүлгийн автомат удирдлагын системийн ажил	9,395.50	20,382,973.52
6	Хуваарилах самбарын ажил	3,067.63	6,655,039.23
7	Хөргөлтийн узелийн ажил	3,158.84	6,852,913.85
Нийт дүн		380,835.59	826,199,962.36

Эх сурвалж: Шинжээчийн дүгнэлт

2.22. Гүйцэтгэгч компани болон захиалагчийн хяналтын инженерүүд 2019 оны 4 дүгээр сарын байдлаар ирээдүйд хийгдэх зарим ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, нийт 380.8 мянган ам.доллар буюу 826.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгуулсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл болон олгосон санхүүжилтийг тулган баталгаажуулахад 1,693.5 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна

2.23. Аудитын явцад гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл болон олгосон санхүүжилтийг тулган баталгаажуулахад гүйцэтгэгчид 250.4м³ бетон зуурмаг, 910.45 тн арматурын үнийг илүү тооцоолж, 1,693.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 15. Илүү тооцсон материалын тоо хэмжээ, үнийн задаргаа

Д/д	Материалын нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /ам.доллар/	Бүгд үнэ	
					ам.доллар	Төгрөг (\$1=₮2169.44)
1	Бетон зуурмаг В 25	м3	250.4	348.3632	87,230.145	189,240,565.77
2	Арматур	тн	910.45	761.571.6	693,372.863	1,504,230,823.90
Нийт дүн					780,603.008	1,693,471,389.67

Эх сурвалж: Шинжээчийн дүгнэлт

2.24. Энэ нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын инженерүүд гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахад үед барилга бүтээцийн угсралтын ажлын зураг хийгдээгүй байснаас тухайн барилга угсралтын ажилд орсон материалын орцын хэмжээг нарийвчлан тодорхойлох боломжгүй байснаас шалтгаалсан байна.

2.25. Иймд гүйцэтгэгч болон захиалагчийн хяналтын инженерүүд 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хамтарсан хурал хийж, барилга бүтээцийн угсралтын ажлын зураг магадлалаар баталгаажиж гарахад тухайн барилгад орсон материалын тоо хэмжээг зурагтай нь тулган баталгаажуулж, санхүүжилт илүү олгогдсон нь тогтоогдвол дараагийн ажлын гүйцэтгэлээс суутган тооцохоор тохиролцож, хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан байна.

Засгийн газрын 2014 оны 93 дугаар тогтоолыг зөрчин захиалагчийн хяналт хийх байгууллагыг сонгосон байна

2.26. Эрүүл мэндийн сайдын “Барилга угсралтын ажилд техник хяналт тавих тухай” 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр болон Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлд техникийн хяналт тавих эрхийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт олгосон байна.

⁴ 1 ам.долларыг Монголбанкны 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн хаалтын ханш 2169.44 төгрөгөөр тооцов.

2.27. Эрүүл мэндийн яам, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газартай 2017 оны 8 дугаар сарын 09-ний өдөр 800.8 сая төгрөгийн “Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга байгууламжийн угсралт, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх” 2017/12 дугаар гэрээг байгуулсан байна.

2.28. Энэ нь Засгийн газрын 2014 оны 93 дугаар тогтоолоор “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний техник хяналтыг Барилга хот, байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвөөр гүйцэтгүүлэх” заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт 16. Захиалагчийн хяналтын зардлын задаргаа

Д/д	Захиалагчийн хяналтын зардал	Эх үүсвэр	Санхүүжилт олгосон огноо	Олгосон санхүүжилтийн дүн	
				Ам.доллар	Төгрөг ⁵
1	Ажлын гүйцэтгэл 1 (IPC 1)	Улсын төсөв	2017.12.28	79,575.42	192,294,798.18
2	Ажлын гүйцэтгэл 2 (IPC 2)	Улсын төсөв	2018.08.24	47,496.49	114,775,743.05
3	Ажлын гүйцэтгэл 3 (IPC 3)	Улсын төсөв	2018.08.24	35,972.65	86,928,268.45
4	Ажлын гүйцэтгэл 4 (IPC 4)	Улсын төсөв	2018.12.26	40,472.96	97,803,312.57
5	Ажлын гүйцэтгэл 5 (IPC 5)	Улсын төсөв	2018.12.26	73,957.05	178,717,950.90
Нийт дүн				277,474.57	670,520,073.15
Үлдэгдэл				53,920.4	130,299,185.85

Эх сурвалж: Төслийн нэгжийн 2017, 2018 оны санхүүгийн тайлан

2.29. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалагчийн хяналтыг өдөр бүр хийх хуваарь гаргаж, хяналтын инженерүүдийг ажиллуулж, хяналтаар хэрэгжүүлсэн ажлын тайланг сар, өдрөөр тогтмол бичиж хэвшсэн бөгөөд барилга угсралтын ажлын үе шат бүрд хийсэн ил, далд ажлын акт, гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан байна.

2.30. Улсын төсвөөс захиалагчийн хяналт гүйцэтгэж байгаа Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт 4 удаагийн ажлын гүйцэтгэл (5 дахь ажлын гүйцэтгэл баталгаажсан дүн ороогүй)-ээр 491.8 сая төгрөг буюу нийт олгох санхүүжилтийн 61.4 хувийг олгосон ч барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл 54.4 хувьтай байна.

Барилгын норм ба дүрмийн дагуу зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж байна

2.31. Эрүүл мэндийн яам, “Бьюлдингс технолоджи” ХХК-тай 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр “Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгэх” 165,697.49 ам.долларын гэрээг байгуулжээ.

Хүснэгт 17. Зохиогчийн хяналтын зардлын санхүүжилт олгосон байдал

Д/д	Зохиогчийн хяналтын зардал	Эх үүсвэр	Санхүүжилт олгосон огноо	Олгосон санхүүжилтийн дүн		Нэг ам.долларыг арилжааны банкны ханшаар тооцов
				Ам.доллар	Төгрөг	
1	Ажлын гүйцэтгэл 1 (IPC 1)	Зээлийн хөрөнгө	2018.05.02	39,787.71	95,410,928.58	2018.05.02 2,398.0 ₮
2	Ажлын гүйцэтгэл 2 (IPC 2)	Зээлийн хөрөнгө	2018.10.23	23,748.24	60,795,494.40	2018/10/23 2,560.0 ₮
3	Ажлын гүйцэтгэл 3 (IPC 3)	Зээлийн хөрөнгө	2018.10.23	17,986.33	46,045,004.80	2018/10/23 2,560.0 ₮
4	Ажлын гүйцэтгэл 4 (IPC 4)	-	-	-	-	-
5	Ажлын гүйцэтгэл 5 (IPC 5)	-	-	-	-	-
Нийт дүн				81,522.28	202,251,427.78	
Үлдэгдэл				84,175.21		

Эх сурвалж: Төслийн нэгжийн 2018 оны санхүүгийн тайлан

2.32. Зохиогчийн хяналтыг гүйцэтгэгч “Бьюлдингс технолоджи” ХХК 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 34 удаа барилгын талбай дээр очиж, барилга угсралтын ажил зураг төслийн дагуу хийгдэж

⁵ 1 ам.долларыг Монгол банкны 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хаалтын ханш болох 2,416.51 төгрөгөөр тооцов.



байгаа эсэхэд хяналт хийж ажлын журналд шаардлагатай зөвлөмжийг бичиж тэмдэглэсэн байна.

2.33. Тус компанид зохиогчийн хяналтын зардалд 81,522.28 ам.доллар буюу нийт олгох санхүүжилтийн 49.2 хувийг олгосон байна.

Барилгын төслийн хэрэгжилтийн явцад холбогдох байгууллагаас хяналт хийж, зөвлөмж өгсөн байна

2.34. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4+ төслийн хэрэгжилтийн шатанд 2016 оноос хойш АХБ-наас 4 удаа, Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2 удаа, Үндэсний аудитын газраас санхүүгийн тайлангийн аудитыг 3 удаа, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг” болон Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/198-А/489 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус тус хяналт шалгалт хийсэн байна.

2.35. Дээрх хяналтаар тус төслийн төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, барилга угсралтын ажлын явцтай холбоотой нийт 24 зөвлөмж өгөгдсөнөөс 19 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 4 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1 зөвлөмж нь АХБ дэмжээгүйгээс шалтгаалан хэрэгжээгүй байна.

Эмнэлгийн гадна бохир усны шугамыг холбосон төвийн шугам ачааллаа даахгүй байх эрсдэл үүссэн байна

2.36. Нэгдсэн эмнэлгийн барилгын гадна бохирын шугам зураг төслийн дагуу ф150 мм хоолойгоор хийгдэж, 62 дугаар сургуулийн хажуу талын төвийн бохир усны шугамтай холбогдсон байна.

2.37. Эмнэлэг бүрэн хүчин чадлаар ажиллах үед тус төвийн бохирын усны шугам ачааллаа даахгүй болж, эмнэлэг бохироо зайлуулах боломжгүйд хүрэх эрсдэл үүсэх магадлал өндөр байгаа тул цаашид холбогдох байгууллагаар тооцоо, судалгаа хийлгэн төвийн бохир усны шугамын диаметрийг өргөтгөх нь зүйтэй байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам (хуучин нэрээр) 2013 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга төсөл”-ийн хэлэлцээрийг Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлага тухайлбал, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулах зэргийг хангаагүй байхад байгуулсан нь төслийн төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрахад нөлөөлсөн байна.
2. Эрүүл мэндийн яам болон төслийн нэгж нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулаагүй зураг, ажлын тоо хэмжээг дутуу тооцсон төсвийг хүлээн авсан нь төсөл хэрэгжүүлэх нэгжид мэргэжлийн шаардлага хангасан мэргэжилтнийг ажиллуулаагүйгээс шалтгаалсан бөгөөд барилгын ажлыг эхлүүлэхэд бэрхшээл үүсгэж, улмаар гүйцэтгэгч байгууллагад 780,603.0 ам.долларын илүү санхүүжилт олгох нөхцөлийг бүрдүүлсэн байна.
3. Эрүүл мэндийн яам 2015 оны 1 дүгээр сард барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулах шийдвэр гаргаж байсан бол түүнээс хойш 1 жил 11 сарын хугацаанд яамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн, тогтвортой ажиллаагүй зэрэг шалтгаанаар 4 удаагийн өөрчлөлт орж, төсөл хэрэгжих хугацаа удаашрахад хүргэсэн байна.
4. Эрүүл мэндийн яам төслийн нэмэлт санхүүжилтийн хэлэлцээр байгуулаагүй байхад ажил гүйцэтгэх гэрээний 4.2, 12.3, 13.1 дэх хэсгийг үндэслэн нэмэлт ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, 3.9 сая ам.долларын санхүүжилтийг олгуулсан байна.
5. Эрүүл мэндийн яам барилга угсралтын ажлын зургийн өөрчлөлтийг тусгасан төсвийг эцэслэн боловсруулж, магадлалаар баталгаажуулах ажлыг гүйцэтгээгүй нь төслийн хэрэгжилт, зээлийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

Зөвлөмж

Аудитаар илрүүлсэн зөрчил, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд:

- Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөх, эрсдэлийн удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллах,
- “Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга төсөл”-ийн зургийн өөрчлөлтөд үндэслэсэн барилгын төсөвт өртгийг төсвийн норм, норматив, дүрэм зааврын дагуу тооцож, хянан баталгаажуулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулах,
- Барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэлээс илүү олгосон 250.4 м.куб бетон зуурмаг, 910.45 тонн арматурын үнэ 780,603.0 ам.долларын санхүүжилтийг гүйцэтгэгчийн дараагийн ажлын гүйцэтгэлээс суутган тооцох,
- Төслийн онцлогт нийцүүлэн төсөл хэрэгжүүлэх нэгжид мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах, гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлж ажиллах.

Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн санал


**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2019 06-03 № 11-2/2488

танай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

Таны ирүүлсэн 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 05/1087 тоот албан бичгийг хүлээн авлаа.

Үндэсний аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр 4 ба нэмэлт 4 төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн хэрэгжилт, үр дүнд эрсдэлийн аудит хийж, тайлангийн төслийг ирүүлсний дагуу Эрүүл мэндийн яам тусгайлан өгөх саналгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

Г.ЭРДЭМБИЛЭГ


1118270972 2.5057443

084866

Хавсралтууд

Хавсралт 1

Барилгын зураг төсөл боловсруулсан болон түүнд магадлал хийсэн мэдээлэл

Зургийн нэр	Хуудасны тоо	Зураг боловсруулсан		Зургийн шифр	Магадлал хийгдсэн огноо	Магадлалын ерөнхий дүгнэлтийн огноо, дугаар
		Он	Байгууллагын нэр,			
Барилгын архитектурын хэсэг						
Барилгын ерөнхий төлөвлөгөө өндөржилт	ЕТ-4	2015	“JUNGLIM ARCHITECTURE” Co., LTD “ЭЗТ” ХХК “БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015	2015.08.28	2015.10.09 1061\2015
Ландшафт	17					
Барилгын гадна талбайн ерөнхий хэсэг	26					
Барилга архитектур	БА-255					
Барилга архитектурын өөрчлөлтөөр						
Барилгын ерөнхий төлөвлөгөө зай хэмжээ	ЕТ-3	2018	“БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015	2018.06.15	2018.06.15 665\2018
Барилга архитектур	БА-44					
Барилгын бүтээцийн хэсэг						
Суурийн бүтээц	ББ-62	2017	“Ган харш” ХХК	ЕГ шифр: ГХ-06\2017	2017.09.27	2017.10.09 717\2017
Барилга бүтээц	ББ-62	2015	“JUNGLIM ARCHITECTURE” Co., LTD “БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015	2015.08.25	2015.10.09 1061\2015
Цэвэр, бохир ус	ЦБУ-26	2015			2015.09.17	2018.04.06 266\2018
Цэвэр, бохир ус засвар өөрчлөлт	ЦБУ-31	2017			2018.04.22	2018.04.06 266\2018
Халаалт, агаар сэлгэлт, хөргөлт						
Халаалт, агаар сэлгэлт, хөргөлт	ХАС-30	2015	JUNGLIM ARCHITECTURE “Co.,LTD “БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015	2015.08.26	2015.10.09 1061\2015
Агаар сэлгэлтийн засвар өөрчлөлт	ХАС-32	2017		ЕГ шифр: BT-10\2015	2018.04.23	2018.06.15 665\2018
Дотор халаалтын засвар өөрчлөлт	ХАС-11	2018		ЕГ шифр: BT-10\2015	2018.04.23	2018.06.15 665\2018
Эмнэлгийн хийн систем						
Хийн систем	36	2015	JUNGLIM ARCHITECTURE “Co.,LTD “БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015	2015.08.26	2015.10.09 1061\2015
Цахилгаан хангамж	44	2015			2015.08.27	2015.10.09 1061\2015
Автомат удирдлага	41	2015			2016.03.03	2018.06.15 665\2018
Автомат удирдлагын засвар өөрчлөлт	52	2018			2018.04.23	2018.06.15 665\2018
Галын систем						
Галын дохиолол	61	2015	JUNGLIM ARCHITECTURE “Co.,LTD “БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015\	2015.09.04	2015.10.09 1061\2015
Галын дохиолол ба хийгээр гал унтраах систем тайлбар бичгийн хамт	15	2017			2018.04.20	2018.06.15 665\2018
Энгийн гал унтраах системийн засвар өөрчлөлт	7				2018.04.22	
Холбоо дохиолол	41	2015	JUNGLIM ARCHITECTURE “Co.,LTD “БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015\	2015.09.04	2015.10.09 1061\2015
Холбооны дохиолын ажлын зураг, тайлбар бичгийн хамт	51	2017	“БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015\	2018.04.20	2018.06.15 665\2018
Хөргөлтийн системийн ажлын зураг	11		“БТ” ХХК	ЕГ шифр: BT-10\2015	2018.04.23	



Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэгийн ажлын зураг	47				2018.04.21	
Дулаан механик	ДМ-7	2017	“БТ” ХХК	ЕГ шифр: ВТ-10\2015	2018.04.23	2018.06.15 655\2018
Гинаторын хэсгийн ажлын зураг \ аваарын нөөц дизель станц\	32			“ЕГ шифр: ВТ-21\2017	2018.04.21	
Гадна инженерийн шугам сүлжээ						
Гадна цахилгаан	6	2015	JUNGLIM ARCHITECTURE " Co.,LTD “БТ” ХХК	ЕГ шифр: ВТ-12\2015	2015 09.09	2015.10.09 1061\2015
Гадна цахилгааны хэсгийн ажлын зураг \ ГЕО 110\10кв-ийн дэд станцын 10 кв-ийн хуваарилах байгууламжид ячейк тоноглох	7	2017			2018 04.21	2018.06.15 665\2018
Гадна гэрэлтүүлэг, фасадны гэрэлтүүлгийн ажлын зураг	12				ЕГ шифр: ВТ-20\2017	
Гадна холбооны ажлын зураг	3	2015	JUNGLIM ARCHITECTURE " Co.,LTD Өрхтгий- өрөмт ХХК	Шифр: Өрх-Ө-08\2015	2015 09.04	2015.10.09 1061\2015
Гадна холбооны кабелийн шилжүүлэгийн ажлын зураг	6			Шифр: Өрх-Ө-07\2015		
Гадна холбооны ажлын зураг	6			2018	Шифр: Өрх-Ө-03\2018	2018 04.10
Гадна дулааны шугам	11	2015	JUNGLIM ARCHITECTURE " Co.,LTD ОТЗТ ХХК	Шифр: ОТ-09-2015	2015 09.23	2015.10.09 1061\2015
Гадна ариутгах татуурга	11	2015	JUNGLIM ARCHITECTURE " Co.,LTD “БТ” ХХК	ЕГ шифр: ВТ-10\2015	2015 09.17	
Гадна ариутгах татуурга	11	2018			УСУГ-аас зөвшөөрөл авсан 2018.03.16	
Түргэн тусламжийн хэсгийн суурьтай давхацаж байгаа дулааны шугам зөөж зайлуулах ажлын зураг	5	2018	ОТЗТ ХХК	Шифр: ОТ-12-2018	УБ хотын Дулааны сүлжээ ТӨХК-аар 2018 07.07-ны хянуулж зөвшөөрөл авсан	
Түргэн тусламжийн хэсгийн дулааны шугамын нэвтрэх сувгийн зураг	5	2018	“БТ” ХХК	ЕГ шифр: ВТ-17\2018		
Түргэн тусламжийн барилгын сууриас зөөх цэвэр усны шугамын ажлын зураг	6	2018	“Түвшинжин” ХХК	Шифр: ТЖ-3.15\2018	УСУГ-аас зөвшөөрөл авсан 2018.08.20	

Барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэлийн хувь
/2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар/

Д/д	Ажлын нэр	Гүйцэтгэлийн хувь
Техникийн барилга		
1.	Газар шорооны ажил	100
2.	Суурийн ажил	100
3.	Төмөр бетон каркас цутгалтын ажил	100
4.	Дээврийн ажил	68
5.	Гадна дотор ханын өрлөгийн ажил	100
6.	Дотор гипсэн ханын угсралтын ажил	49
7.	Гадна ханын хөөсөн фасадын ажил	100
8.	Гадна хаалга цонхны ажил	100
9.	Дотор заслын ажил	5
10.	Халаалтын системийн ажил	56
11.	Агаар сэлгэлтийн систем	24
12.	Хөргөлтийн систем	0
13.	Эмнэлгийн хийн хангамжийн систем	0
14.	Цахилгаан хангамж	6
15.	Бага хүчдэлийн систем	6
16.	ЦБУ шугамын ажил	4.5
17.	Эмнэлгийн тоног төхөөрөмж угсрах	0
18.	Техникийн барилгын пандус	80
19.	Цахилгаан шат	0
Үндсэн барилга: А, Б, подиумын барилга		
1.	Газар шорооны ажил	100
2.	Суурийн ажил	100
3.	Төмөр бетон каркас цутгалтын ажил	100
4.	Дээврийн ажил	68
5.	Гадна дотор ханын өрлөгийн ажил	100
6.	Дотор гипсэн ханын угсралтын ажил	50
7.	Гадна ханын хөөсөн фасадын ажил	100
8.	Шилэн фасадын ажил	100
9.	Гадна хаалга цонхны ажил	95
10.	Дотор заслын ажил	25
11.	Халаалтын системийн ажил	70
12.	Агаар сэлгэлтийн систем	6
13.	Хөргөлтийн систем	0
14.	Эмнэлгийн хийн хангамжийн систем	0
15.	Цахилгаан хангамж	70
16.	Бага хүчдэлийн систем	18
17.	ЦБУ шугамын ажил	30
18.	Эмнэлгийн тоног төхөөрөмж угсрах	0
19.	Цахилгаан шат	0
20.	Гадна дулаан хангамж	100
21.	ЦБУ, ГШС-ны ажил	100
22.	Гадна тохижилт	0
Нийт барилга		
1.	Техникийн барилга	50.2
2.	А блок	60.75
3.	Б блок	54.8
4.	Подиумын барилга	51.9
Барилгын нийт гүйцэтгэл		54.4



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.